

МОНГОЛ БА ОХУ-ЫН 1990-ЭЭД ОНЫ ХАРИЛЦААГ ҮЕЧЛЭН АВЧ ҮЗЭХ НЬ

Б.ЛХАМСҮРЭН¹

XX зууны 90-ээд оны эхнээс Монгол улс ба түүний умард хөрш гүрний харилцаанд цоо шинэ байдал бий болж ихээхэн өөрчлөлт гарав. Энэ нь өрнө, дорны хоорондын “хүйтэн” дайны үе төгсгөл болж дэлхийн социалист систем задарч түүний бүрэлдэхүүнд байсан ЗСБНХУ /түүний залгамжлагч гол орон ОХУ/, БНМАУ-ын аль алинд нийгмийн ардчилсан өөрчлөлт өрнөсөнтэй холбоотой.

Өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд тус хоёр улс хөгжлийн хуучин загвар, явцуу үзэл баримтлалаас татгалзсан нь тэдгээрийн бие биенээс хөндийрэх шалтгаан огтхон ч болох ёсгүй билээ. Учир нь Монгол, Оросын ард түмний найрсаг сайн хөршийн харилцаа нь олон жилийн түүхэн уламжлалтай гүнзгий бодит үндэстэй юм, тэдгээрийн заримыг дурьдвал:

-Орос улс бол XX зуунд олон улсын харилцааны хүнд ээдрээтэй нөхцөлд Монголын туурга тусгаар улсаа байгуулан хөгжүүлэхийг сонирхон дэмжиж ирсэн их гүрэн;

-Азийн бөглүү газар орших Монгол улсыг гадаад ертөнцтэй хуурай ба агаарын харилцаа, далайн гарцаар хангаж байгаа, Европ Азийг дамнасан нутагтай, 3485 км газраар хиллэсэн манай умард хөрш орон;

-Хүн ардын өргөн давхарга нь Монгол ба монголчуудын тухай мэдлэгтэй, хэл соёлын нийтлэг бүхий монгол туургатны нэгжүүдийг бүрэлдэхүүндээ багтаасан олон үндэстний улс;

-Монголын дотор Орос улсын харьяат нарын тоо цөөн /1500 орчим/ бөгөөд тэд монголчуудтай ямар нэгэн мөргөлдөөнгүйгээр тус оронд аж төрж байдаг билээ.

Тэгвэл өнгөрч буй 10 жилийн хугацаанд Орос, Монголын хоорондын харилцаа ямар учраас сулран саарав гэдэг асуудал зүй ёсоор тавигдаж байна. Бид энэ асуудалд хариулахын тулд тус хоёр орны улс төр, эдийн засгийн байдал, гадаад бодлогод холбогдох үйл явц, өөрчлөлтийг үе шаттайгаар задлан үзвэл зохино. 90-ээд оны Монгол-Оросын харилцааны явц байдлыг 1991-1995, 1996-1999, 2000 оноор зааглан гурван үе болгон үзмээр байна.

¹Б.Лхамсүрэн – Академич, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн зөвлөх

1. Монгол-Оросын харилцаа буурсан үе. /1991-1995/

Энэ үеийг тусгайлан авч үзэхийн үндэс нь Монгол-Оросын хоорондын эдийн засгийн харилцаа эрс хорогдсон явдал юм. 1990 онд Монголоос Орос улсад гаргасан экспортын хэмжээ 517,5 сая ам.доллар байсан бол 1995 онд 68,5 сая ам.доллар болтол буурч Монголд Оросоос оруулсан импорт мөн хугацаанд 951,6 сая.ам.доллараас 208 сая ам.доллар хүртэл доошилсон байна.¹

Монголын гадаад худалдааны эргэлтэд 80 хүртэл хувийг эзэлж байсан Оросын худалдаа ийнхүү үлэмж хэмжээгээр буурсан нь Монголын эдийн засаг, нэн ялангуяа мал аж ахуй, газар тариалан, тэдгээрийн бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэрийн салбарт ихээхэн хүндрэл учруулсан юм.

1990-1993 оны хооронд Монголын ДНБ 208,6 тэрбум төгрөгөөс 170 тэрбум төгрөг хүртэл буурч үйлдвэрлэлийн хэмжээ нийтдээ 22%-иар унасан байна.²

Энэ үед Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдэд Оросын пүүсүүдийн хөрөнгө оруулалт багасч Монголын эдийн засагт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтад 10 орчим хувийг эзэлж Хятад, Японы хөрөнгө оруулалтын дараа гуравдугаар байранд орох болжээ.

90-ээд оны эхний хагаст ОХУ-ын өөрчлөн байгуулалтын явцад олон талын хүндрэл бэрхшээлтэй учирч гадаад харилцаандаа өрнөдийнхөнд түшиглэсэн чиг бодлогыг явуулан дотооддоо эдийн засгийн тогтворгүй байдал, санхүү хууль эрхийн салбарт авилгал, мафийн сүлжээ бий болсон зэрэг нь Орос-Монголын харилцааг зохих түвшинд хөгжүүлэхэд саад болсон талтай.

1993 оны 1 дүгээр сарын 20-нд Москвад гарын үсэг зурсан Монгол ба ОХУ-ын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ нь социалист систем задарсан нөхцөлд тус хоёр улс гадаад бодлогоо шинэчлэх, дотооддоо ардчилсан өөрчлөлт хийх шаардлагаас зүй ёсоор үүдэн гарсан юм. Энэхүү гэрээгээр хоёр талууд хоорондынхоо харилцааг шинэчлэж 1996 оны гэрээгээр тунхагласан социалист интернационализмын баримтлал болон цэргийн холбооны үүргээс татгалзаж түгээмэл ардчилсан зарчмыг баримталсан байна. ОХУ-ын ерөнхийлөгч Б.Н.Ельцин энэхүү баримт бичигт гарын үсэг зурах үеэр түүнийг “хоёр орны харилцааны “том ах”, “бага дүү”-гийн хуучин зарчмыг халж тэгш эрхтэй харилцан ашигтай харилцаа хөгжүүлэх найрсаг хамтын ажиллагааны гэрээ” гэж тэмдэглэн хэлж байжээ.

¹ П.Лувсандорж нар. Монголын эдийн засаг. Шилжилтийн эдийн засгийн гарын авлага. УБ. Манчестер, 1999 он, 165-166 тал

² Мөн тэнд, 80-81-р тал.

Уг гэрээнд “талууд бие биеэ найрсаг улс хэмээн үзэх бөгөөд өөр хоорондын харилцаанд бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэх, адилхан бүрэн эрхтэй байх, хүч үл хэрэглэх буюу хүчээр сүрдүүлэхгүй байх, хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, хүний эрх болон үндэсний эрх чөлөө, улс түмний тэгш эрх, хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг хүндэтгэх, хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэх, сайн хөрш түншийн ёсоор хамтран ажиллах зарчмуудыг удирдлага болгоно” гэж заажээ.³

Эдгээр зарчим бол НҮБ-ын дүрмээр баталсан улс хоорондын харилцааны үндсэн зарчим мөн бөгөөд хоёр тал тэдгээрийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн бүхий л харилцаагаа цаашилд хөгжүүлэхээр тохиролцжээ.

Уул гэрээнд Монгол ба ОХУ-ын ерөнхийлөгч П.Очирбат Б.Н.Ельцин нар гарын үсэг зурахын хамт 30-40-өөд онд ЗСБНХУ, БНМАУ-д үй олон хүмүүсийг хоморголон хэлмэгдүүлсэн явдалд харамсаж байгаагаа илэрхийлсэн тусгай мэдэгдэл гаргаж түүндээ “Монгол улсын олон иргэд ЗСБНХУ-д хэлмэгдэж цаазлагдсан юм. Хэдий тийм боловч түүний хариуцлага өнөөгийн Орос улсад холбогдолгүй бөгөөд... Монгол улс, ОХУ сталинч хэлмэгдүүлийг зэмлэн буруушааж түүхэн үнэнийг сэргээх, иймэрхүү үйлдлийг дахин давтуулахгүй байх бүхий л арга хэмжээ авна” гэдгээ мэдэгджээ.⁴

Тухайн үед Монголд явуулсан сталинч хэлмэгдүүлэл нь мөн чанартаа тус улсын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох зарчмыг бүдүүлгээр зөрчсөний ноцтой илрэл байсан тул энэхүү мэдэгдэл нь хоёр улсын хоорондын харилцааны ардчилсан зарчмыг тууштай баримтлах эрмэлзлийн баталгаа болж өгсөн юм.

2. Орос-Монголын харилцааны түвшин тогтонги байдалд орсон үе /1995-1999/

ОХУ ардчилсан шинэчлэлийг хэрэгжүүлж эхлэхээс аваад Өрнөдийг шүтэх бодлого баримталж байсны үр дагалдал нь 90-ээд оны II хагаст хурцаар илэрсэн юм.

Олон улсын харилцааны хүрээнд ОХУ-ын их гүрний байр суурь илт суларсаар байв. НАТО дорнод Европ руу хүрээгээ тэлж улмаар ТУХН-ын зарим орнуудад ч нөлөөлөх болов.

Бүс нутгийн зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхэд Орос улсын сонирхлыг үл тоомсорлох хандлага Ойрхи Дорнод болон Косовогийн хэрэг явдал дээр тод харагдав. Стратегийн зэвсэглэл, цөмийн хүчин

³ “Ардын эрх” сонин. 1993. №56.

⁴ П.Очирбат. Тэнгэрийн цаг, 209-р тал.

чадлаа хорогдуулан, батлан хамгаалах аж үйлдвэрийг өөрчлөх талаар Орос улсаар буулт хийлгэх, Энэтхэг, Иран зэрэг оронтой явуулж буй цөмийн хамтын ажиллагааг цуцлуулахыг эрмэлзэх болов. Дэлхий хоёр системд хуваагдахаа больсоны дараа АНУ-гаар тэргүүлсэн нэгэн туйлт ертөнц бүрэлдэх тухай үзэл баримтлал газар авсаар байв. АНУ-ын геостратегийн бодлогыг бүтээгч гэгддэг З.Бжежинский: “Нийт Евро-Азийн хувьд иж бүрэн түгээмэл урт хугацааны геостратегийг боловсруулан хэрэглэх цаг АНУ-д тулгаран ирлээ. Ингэхийн чухал учир нь Америк эдүгээ цорын ганц хэт их гүрэн болсон, Евроази ертөнцийн төв талбар болсон энэ хоёр үндсэн бодит байдлын харилцан үйлчлэлээс үүдэж байна”⁵ гэж уул үзэл баримтлалын мөн чанарыг тодорхойлжээ.

ОХУ-ын удирдагчид энэ бүхэнд дүгнэлт хийж 90-ээд оны дундуураас олон туйлт ертөнцийн үзэл баримтлалын үүднээс гадаад бодлогодоо засвар хийхэд хүрэв. Гэвч гадаад бодлогын шинэчлэл нь гол төлөв Европ Азийн их гүрнүүдэд хандаж хил залгаа бага улс орнуудыг тойрсон байдалтай байв. Үүнийг энэ үед Орос ба бусад улсын хооронд хийж байсан дээд хэмжээний уулзалтуудын чиг хандлага, тухайлбал Орос-Монголын хооронд ийм хэмжээний айлчлалын урсгал Монголын талаас голлож нэг чиглэлтэй байсан явдал харуулж байв. Оросын ерөнхий сайд В.С.Черномырдин, ерөнхийлөгч Б.Н.Ельцин нар Монголд айлчлах урилгаа хэрэгжүүлээгүй билээ.

90-ээд оны II хагас ОХУ-ын дотоод байдал ихээхэн хямарсан жилүүд байв. Энэ нь эдийн засгийн салбарт ДНБ-ий үлэмжхэн бууралт газар тариалангийн үйлдвэрлэлийн зогсонги байдал, гадаад өрийн өсөлт зэргээр тодорхойлогдож байв.

Улс төрийн хүрээнд нөлөө бүхий хэсэг бүлгийн сонирхлын үндсэн дээр засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдаж, төв ба орон нутгийн харилцааны зөрчил, санхүү үйлдвэр худалдааны олигархийн эрх мэдэл хүчтэй болж зохион байгуулалттай гэмт хэрэг газар авсан байна. Чеченд 1994-1996 онд дэгдсэн дайн ба 1999 онд түүний сэдэрсэн үргэлжлэл бол Оросын дотоодын доргилтын ноцтой голомтын нэг юм. Орос орны улс төрийн байдал нэн тогтворгүй байсныг тус улсын засгийн газар энэ үед таван удаа солигдсон явдал харуулж байв.

Дурдсан хугацаанд Монгол улсад эдийн засаг нийгмийн сөрөг үзэгдэл даамжирсаар ноцтой хямрал болон хувирсан билээ.

90-ээд оны дундуураас тус оронд их хувьчлалыг хэрэгжүүлэхдээ ихэнх тохиолдолд төрийн хяналтын дор ил тод явуулах зарчмыг зөрчсөнөөс эдийн засгийн байдал улам доройтов. Үндэсний үйлдвэрлэл уналтад орж газар тариалангийн үйлдвэрлэл жил дараалан

⁵ З.Бжежинский. Великая шахматная доска. М.1999, стр.230.

буурч экспортын хэмжээ доошилсоор байв. Арилжааны ихэнх банкны төлбөрийн чадвар доройтож заримыг нь зохион байгуулалттай дампууруулснаас банкны өрийн үлдэгдэл 70 гаруй тэрбум төгрөгт хүрчээ. Энэ жилүүдэд хөдөлмөрийн чадвартай ажилгүйчүүдийн тоо 200 мянгад хүрч Монголын гурван хүн тутмын нэг нь амьдралын баталгаажсан түвшингээс доогуур ядуу амьдарч байв.

Улсын Их Хурлын олонх болон засгийн газрын гишүүдийн дотор авилгал, хээл хахуульд автах, эрүүгийн ноцтой гэмт хэрэгт холбогдох явдал илэрч дөрвөн жилийн дотор гурван засгийн газар огцорсон нь тус улс засаглалын ноцтой хямралд орсны илрэл байв.

Монгол улс олон тулгуурт гадаад бодлого явуулахдаа үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг дээдэлж түүнийг хангахад шийдвэрлэх роль бүхий бодит хөршүүдтэй харилцах харилцааг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл гэж үздэг билээ. Гэтэл үүнийг үл хайхрах хандлага Монголын засгийн газрын үйл ажиллагаанд илэрч байлаа. Тухайлбал, 1996 онд батласан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “АНУ-тай тогтоосон хамтын ажиллагааг манай гадаад бодлогын түшиг тулгуур” гэж дөвийлгөн өрөөсгөл шугамыг баримтлах буюу цэрэг-улс төрийн эвсэл -НАТО-гийн “энхийн төлөө түншлэл” хөтөлбөрт оролцох зарим алхам хийж байв. Энэ нь үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалын тухай хуулиудын заалтыг гажуудуулснаас гадна хөрш гүрэнтэй байгуулсан найрсаг харилцааны тухай гэрээгээр нөгөө этгээдийн эсрэг чиглэсэн гурав дахь хүчний аливаа явуулгад өртөхгүй байхаар авсан үүрэгт харш алхам байв.

Нөгөө талаар Монгол-Оросын хоорондын харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж болох үзэгдэл ОХУ-ын дотор ажиглагдаж байв. Жишээ нь Оросын Думын геополитикийн асуудал эрхэлсэн хорооны дарга ОЛАН-ын зүтгэлтэн А.В.Митрофанов 1997 онд хэвлэгдсэн номдоо “Их тал нутгийн нүүдэлчин овогтны заналхийллээс түүхийн дагуу сэргийлсээр ирсэн Хятадын болгоомжлолыг хуваалцаж Версаль-Потсдамын нуран унасан тохиролцооны хэлтэрхий-Гадаад Монгол /БНМАУ/-ыг Хятадын суверенитетэд шилжүүлэхийг” уриалсан байна.⁶ Иймэрхүү сурталчилгааг Азийн зарим их гүрэнтэй ОХУ стратегийн түншлэл тогтоох далбаан дор хөрш зэргэлдээ бага улсыг золиослохоос үл буцах их Оросын неоимперлиг бодлоготны байр суурь хүчтэй байгаагийн илрэл гэж үзэхээс өөр аргагүй.

90-ээд оны II хагаст Монгол-Оросын хамтын ажиллагааг өмнөх үеийн уналтын түвшинд бага зэргийн хэлбэлзэлтэй тогтонги байдалд орсон гэж үзэж болохоор байна. Энэ нь хоёр орны хоорондын бараа эргэлтийн байдал дээр илэрхий байгаа юм.

⁶ А.В.Митрофанов. Шаги новой геополитики.М.1997, стр.203.

**Монгол-ОХУ-ын хоорондох бараа эргэлт
1996-1999 онд /АНУ-ын сая доллараар/⁷**

Он	1996	1997	1998	1999
Монголын экспорт	87,5	46,6	46,8	48,2
Монголын импорт	154,9	160,5	150	149,8
Нийт бараа эргэлт	242,2	207,1	196,8	198

1996 оноос дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ унаснаар Монголын экспортын гол бүтээгдэхүүн үнийн дүнгээр буурах байдалтай байв. ОХУ-аас Монголд оруулдаг импортын гол зүйл-нефтийн бүтээгдэхүүн, цахилгаан эрчим хүчний үнэ харьцангуй өндрөөс гадна үе үе тасалдаж тус орны эдийн засагт хүндрэл учруулж байв.

Монгол дахь ОХУ-ын буюу Орос-Монголын хамтарсан аж ахуйн газар 150 орчим ажиллаж байсан боловч тэдгээрийн хөрөнгө оруулалтын хэмжээнд энэ завсар дорвитой өсөлт гарсангүй.

Монголын экспортын уламжлалт бараанд ноогдуулдаг татвар хязгаарлалтыг багасгах, хил гаалийн элдэв саад бэрхшээлийг арилгах, худалдааг либералчлах, иргэдийн харилцан визгүй зорчих журамд шилжих асуудал янз бүрийн түвшинд хэлэлцэгдэж байсан боловч шийдвэрлэгдэхгүй хойшилсоор иржээ. Нэн ялангуяа соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарт хоёр орны хамтын ажиллагаа хоцрогдонгуй байв.

Хоёр улсын засгийн газрын хоорондын комиссын хүрээнд бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг эрхэлсэн дэд комиссыг 1996 онд байгуулсан явдал нааштай алхам болсон байна. Үүнд: Буриад улсын ерөнхийлөгч, Эрхүү ба Кемерово мужийн амбан захирагч нар Монголд айлчилж холбогдох хэлэлцээр байгуулан бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

⁷ Г.Төмөрчулуун. Процесс принятия внешнеполитических решений в малых государствах (На примере Монголии) М, 1999, стр.51-52. Монгол улс, ОХУ-ын харилцааны лавлах. "Үнэн". 2000.11.14

3. Монгол-Оросын харилцааны шинэ үе. /2000 оноос хойш/

Сүүлчийн бүтэн хагас жилд ОХУ-ын дотоод гадаад байдалд үлэмжхэн өөрчлөлт оруулсан чухал үйл явдлууд болов. Тэдгээрийн дотроос үр дагавраараа нэн чухал нь Ерөнхийлөгч Б.Н.Ельцины арван жилийн засаглал төгсгөл болж түүний эрх мэдэл 1999 оны 8-р сараас ерөнхий сайдаар томилогдсон В.В.Путинд шилжсэн явдал юм. В.В.Путин 2000 оны эхнээс ОХУ-ын Ерөнхийлөгчийн үүргийг хүлээн авч мөн оны гуравдугаар сард болсон бүх нийтийн сонгуульд итгэлтэй ялалт байгуулжээ.

ОХУ-ын шинэ ерөнхийлөгч өөрийн үйл ажиллагааг тус улсын дотоод, гадаад бодлогын гол шугам, зарчмыг тодорхойлсон үндсэн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулахаас эхэлсэн юм.

2000 оны 1-р сард ОХУ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 6-р сард гадаад бодлогын үзэл баримтлалын шинэчилсэн хувилбарыг батламжлан гаргав.

Эдгээр баримт бичгийн онцлог шинж нь Орос улсын язгуур ашиг сонирхол, газарзүйн байршлыг харгалзан өрнө дорнын улсуудтай эрх тэгш тэнцүү харилцах, Оросын хилийн эргэн тойрон сайн хөршийн бүсийг бүрдүүлэх, Азийн улс орнуудтай харилцаагаа идэвхжүүлэх явдал юм.

Бидний авч үзэж байгаа хугацаанд Монголд гарсан гол өөрчлөлтүүд 2000 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар МАХН-аас нэр дэвшигчид үнэмлэхүй олонхи болж нэг намын засгийн газрыг бүрдүүлсэнтэй холбоотой.

Олон улсын харилцааны хүрээнд Монголын шинэ засгийн газар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим чиглэлийг тууштай хэрэгжүүлэх, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн биеэ даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулахаа илэрхийлсэн байна. Тус засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрш орнуудтай сайн хөршийн найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг уламжлал, итгэлцлэлд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэхийг эрхэмлэж "ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг Монгол улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний заалт, үзэл санааны дагуу бүх салбар чиглэлээр өргөтгөн хөгжүүлж, хуримтлагдсан асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэнэ" гэж тусгайлан заажээ.⁸

Ийнхүү Монгол-Оросын харилцааны сааралт, тогтонги байдлыг гэтлэн давж шинэ шатанд гаргаж хөгжүүлэх нөхцөл бүрдэв.

⁸ "ҮНЭН" 2000.09.08.№166.

Энэ нь Монгол ба ОХУ-ын хоёр талын чин хүсэл эрмэлзэл, нийтлэг байр суурийн тусгал мөнийг 2000 оны 11-р сард ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины Монголд хийсэн айлчлал, ерөнхийлөгч Н.Багабандитай хийсэн хэлэлцээ, түүний үр дүн нотолж байна.

ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин цаг үеийн сорилтыг давсан Монгол-Оросын сайн хөршийн харилцааг харилцан туслах хамтран ажиллах олон жилийн бат зузаан уламжлалын үндсэн дээр сэргээн хөгжүүлэх шийдвэр төгс байгааг илэрхийлэн “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзлэдэг” гэж цохон тэмдэглэж байв.⁹

Хоёр улсын ерөнхийлөгчийн гарын үсэг зурсан тунхаглалд хоёр тал аль нэгнийхээ эсрэг цэрэг-улс төрийн эвсэлд үл оролцох, нөгөө талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд харшилсан гэрээ хэлэлцээрийг гурав дахь улстай байгуулахгүй байх, түрэмгийлэл буюу хүчирхийллийн үйлдэл явуулахад зориулж нутаг дэвсгэрээ үл ашиглуулах үүрэг хүлээснээ дахин нотолж орчин үеийн олон улсын тулгамдсан асуудлуудын талаар ижил буюу ойролцоо байр суурьтай байдгаа илэрхийлсэн нь Монгол Оросын сайн хөршийн харилцааг бүрэн итгэлцэлд тулгуурлан хөгжүүлэх эрмэлзлийн баталгаа мөн.

Улаанбаатарын тунхаглалд Монгол-Оросын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс худалдааг чөлөөтэй болгон хөгжүүлэх, түүний дотор төмөр замын тээврийн тариф, гаалийн татвар, бусад хураамжийг хөнгөлттэйгээр тогтоох асуудлыг 2000 онд багтаан шийдвэрлэхийг холбогдох байгууллагуудад даалгаж, Монгол-Оросын хамтарсан томоохон үйлдвэрүүдийг шинэчлэн тоноглох, хамтарсан үйлдвэрүүдийг шинээр байгуулах, Монголын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтын ажиллагааг сэргээх, бүс нутгийн болон хил орчмын харилцааг өргөтгөн гүнзгийрүүлэхээр тохиролцож Зүүн хойт Азийн эрчим хүчний томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол улс оролцохыг Оросын тал дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Мөнхүү тунхаглалд хоёр тал цэргийн болон цэрэг техникийн хамтын ажиллагааг сэргээх, хил дээр зохих дэг журмыг сахиулах, хилийг шалгах хамтарсан комиссын ажлыг дуусгах, иргэдийн харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх асуудлыг боловсруулах, байгаль орчныг хамгаалах талаар идэвхтэй хамтран ажиллахаар тохиролцож хоёр орны ард түмний оюуны болон соёлын нягт хэлхээ холбоог бататган бэхжүүлэх тухай заалтуудыг тусгасан байна.

Монгол Оросын дээд хэмжээний уулзалтын явцад хоёр улсын харилцаанд хэл амаа ололцохгүй асуудал байхгүйг хоёр тал тэмдэглэж байв. Хоёр улсын харилцааны уламжлагдан үлдсэн зарим асуудал,

⁹ “Зууны мэдээ”. 2000.11.15.

түүний дотор Монголоос ОХУ-д төлөх өрийн асуудлыг ч олон жилийн турш баримталсан бие биеэ харилцан нэн дотночлон үзэх зарчмын үндсэн дээр шийдвэрлэх боломжтой нь харагдаж байв.

Дээр дурдсаны үндсэн дээр Улаанбаатарт Монгол-Оросын хооронд дээд хэмжээнд хийсэн яриа хэлэлцээр, тус орны харилцааг шинэ шатанд дэвшүүлэн гаргах түүхэн чухал ач холбогдолтой болсон гэж хэлэх бүрэн үндэстэй байна.